

# Шинээр ирж буй гадаад ажиллах хүчнийг хүлээн авах ба нийгэмшүүлэх нийгмийн төлөөх үйл ажиллагаа

---



## 出入国在留管理庁

Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух  
хяналтын газар

Сүүлийн үеийн мэдээ мэдээллийг доорх (Япон  
улсын Хууль зүйн яамны цахим  
хуудас)холбоосоос харна уу.

Шинээр ирсэн гадаад ажиллах хүчнийг хүлээн  
авах (Оршин суух зөвшөөрөл “Тусгай ур  
чадвартай ажилтан” бий болсон тухай гэх мэт)  
[http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri01\\_00127.html](http://www.moj.go.jp/nyuukokukanri/kouhou/nyuukokukanri01_00127.html)


[Баримт бичиг (Агуулгын жагсаалт)]

1	Япон улсад оршин суугаа гадаадын иргэдийн тоон үзүүлэлт	1
2	Оршин суух зөвшөөрлийн төрөл	2
3	Оршин суугаа гадаадын иргэдийн тоо: Визийн ангилал, иргэншлээр (2019 он 6-р сарын сүүлийн байдал)	3
4	Гадаад ажилчдын тоон үзүүлэлт	4
5	Гадаадын ажилтан хүлээн авах тухай	5
6	Тогтолцооны ерөнхий агуулга ①Оршин суух зөвшөөрлийн тухай	6
7	Салбар бүрийн бодлогууд (14 салбар)	7
8	Ур чадварын дадлага болон тусгай ур чадварын тогтолцооны харьцуулалт (Ерөнхийагуулга)	10
9	Тогтолцооны ерөнхий агуулга ②Хүлээн авагч байгууллага болон бүртгэлтэй дэмжих байгууллагын тухай	11
10	Тогтолцооны ерөнхий агуулга ③Хөдөлмөр эхлүүлэх хүртэлх төлөвлөгөө	12
11	Дэмжлэгийн төлөвлөгөөний ерөнхий агуулга ①	13
12	Дэмжлэгийн төлөвлөгөөний ерөнхий агуулга ②	14
13	Бүртгэлтэй дэмжих байгууллага гэж юу вэ?	15
14	Өргөдөл өгөх тухай (ХАБ,БДБ)	16
15	ТУЧ-ын тухай салбар бүрийн зөвлөл	17
16	“ТУЧА”-ны талаарх хоёр талын гэрээ (МОС)-ний ерөнхий агуулга	18
17	ТУЧ-ын тогтолцооны ажиллагааны ерөнхий нөхцөл байдал	19
18	Үндсэн бодлого, эрх бүхий яамны захирамжийн тухай	21
19	Гадаад ажиллах хүчнийг хүлээн авах цогц арга хэмжээ	30
20	Лавлагаа	36

# Япон улсад оршин суугаа гадаадын иргэдийн тоон үзүүлэлт



出入国在留管理庁  
Хилийн шалган нэвтрүүлэх,  
оршин суух хяналтын газар



\* Дээрх онуудын сүүлчийн байдлаар 2011 он хүртэл бүртгэлтэй гадаадын иргэд, 2012 оноос хойш оршин суух бүртгэлтэй гадаадын иргэдийн тоо тэмдэглэгдсэн байна.

# Оршин суух зөвшөөрлийн төрөл



出入国在留管理庁  
Хилийн шалган нэвтрүүлэх,  
оршин суух хяналтын газар

## Ажил хөдөлмөр эрхлэх эрх бүхий оршин суух зөвшөөрөл (Үйл ажиллагааны хязгаартай)

Оршин суух зөвшөөрөл	Жишээ
Гадаад харилцаа	Гадаад орны засгийн газрын элчин болон төлөөлөгч, түүний гэр бүл
Олон нийтийн ажил	Гадаад орны засгийн газрын ажилтан, түүний гэр бүл
Профессор	Их дээд сургуулийн профессор гэх мэт
Соёл урлаг	Хөгжмийн зохиолч, зураач, уран зохиолч гэх мэт
Шашин	Гадаадын шашны байгууллагаас илгээсэн номлогч гэх мэт
Хэвлэл мэдээлэл	Гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагч, зураглаач гэх мэт
Өндөр мэргэжилтэн	Тодорхой шаардлага дүүргэсэн өндөр мэргэжилтэй хүний нөөц
Бизнесийн удирдлага, менежмент	Бизнесийн эрхлэгч, менежер гэх мэт
Хууль эрх зүй, нягтлан бодогч	Хуульч, мэргэшсэн нягтлан бодогч гэх мэт
Анагаах ухаан	Эмч, Шүдний эмч, сувилагч гэх мэт
Судалгаа	Төрийн болон хувийн байгууллагын судлаач гэх мэт
Боловсрол	Дунд, ахлан сургуулийн гадаад хэлний багш гэх мэт
Технологи, хүмүүнлэг, олон улсын үйл ажиллагаа	Механик инженер, орчуулагч, дизайнер, гадаад хэлний багш гэх мэт
Компанийн салбар луу шилжин ирэх	Гадаадын салбараас шилжин ирсэн ажилтан
Асаргаа сувилгаа	Асрамжийн ажилтан
Урлаг спорт	Жүжигчин, дуучин, тамирчин гэх мэт
Ур чадвар	Гадаадын үндэсний хоолны мэргэжлийн тогооч, спортын удирдагч гэх мэт
Тусгай ур чадвартай ажилтан (Жич:1)	Тусгай аж үйлдвэрийн салбаруудын ажилтан (Жич:2)
Ур чадварын дадлага	Ур чадварын дадлагажигч

(Жич: 1) 2019 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхэлсэн  
(Жич: 2) Асаргаа, сувилгаа, барилга байгууламжийн цэвэрлэгээ, эд анги, хэв үйлдвэрлэл, аж үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, цахилгаан, цахим мэдээллийн холбогдох үйлдвэрлэл, барилга, хөлөг онгоц, усан онгоцны үйлдвэрлэл, автомашины засвар үйлчилгээ, агаарын тээвэр, зочид буудал, хөдөө аж ахуй, загас агнуурын аж ахуй, хүнсний үйлдвэр, нийтийн хоолны салбар  
(2018 оны 12-р сарын 25-нд батлагдав)

## Хувь хүний нийгэмд эзлэх байр суурийг үндэслэн олгогдох оршин суух зөвшөөрөл (Үйл ажиллагааны хязгааргүй)

Оршин суух зөвшөөрөл	Жишээ
Байнгын оршин суугч	Байнгын оршин суух зөвшөөрөл бүхий гадаадын иргэн
Япон улсын иргэний гэр бүл	Япон улсын иргэний эхнэр/нөхөр, төрсөн буюу үрчилсэн хүүхэд
Байнгын оршин суугчийн гэр бүл	Байнгын оршин суугч болон тусгай байнгын оршин суугчийн эхнэр/нөхөр, Япон улсад төрсөн ба үргэлжлүүлэн оршин суудаг хүүхэд
Цагаачлал	Япон иргэний гуравдагч үе буюу бусад орны цагаачлал болсон Япон хүний удам 3 дахь үе нь, Гадаад эхнэр/нөхрийн хүүхэд

## Үйл ажиллагааны чиглэлээс хамааран заагдсан хүрээнд ажил хөдөлмөр эрхлэх оршин суух зөвшөөрөл

Оршин суух зөвшөөрөл	Жишээ
Тусгай үйл ажиллагаа	Дипломат төлөөлөгчийн гэрийн ажилтан, Working holiday гэх мэт

## Ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй оршин суух зөвшөөрөл (\*)

Оршин суух зөвшөөрөл	Жишээ
Соёлын үйл ажиллагаа	Япон соёлын судлаач
Богино хугацаагаар оршин суугч	Жуулчин, Хурал уулзалтын оролцогч
Суралцах	Их дээд сургууль, мэргэжлийн сургууль, Япон хэлний сургууль зэргийн оюутан
Сургалт	Аспирант
Гэр бүлийн виз	Ажил хөдөлмөр болон бусад шалтгаанаар оршин суугаа гадаадын иргэний эхнэр/нөхөр, хүүхэд

\* Зөвшөөрлөөс гадуурх үйл ажиллагааны зөвшөөрөл авсан тохиолдолд тодорхой хэмжээний хөдөлмөр эрхлэх боломжтой


# Оршин суугаа гадаадын иргэдийн тоо: Визийн ангилал, иргэншлээр (2019 он 6-р сарын сүүлийн байдал)




出入国在留管理庁  
Хилийн шалган нэвтрүүлэх,  
оршин суух хяналтын газар

Оршин суугаа гадаадын иргэдийн тоо (Нийт)  
2,829,416


Визийн ангиллаар



Иргэншлээр



# Гадаад ажилчдын тоон үзүүлэлт



Эрүүл мэнд, хөдөлмөрийн яам “Гадаадын иргэдийн хөдөлмөрийн байдлын индекс”-нд үндэслэн гаргав (Тус онуудын 10-р сарын сүүлчийн байдлаар)

**① Нийгэм дэх байр сууринаас шалтгаалан оршин суугаа гадаадын иргэн 532,000 хүн**  
 (“Цагаачлал” (Голдуу Япон хүний удам), “Байнгын оршин суугч”, “Япон улсын иргэний гэр бүл” гэх мэт)  
 • Эдгээр ОСЗ нь үйл ажиллагааны хязгааргүй тул аль ч салбараар ажиллах боломжтой.

**② Ажлын визний төлөө олгогдох оршин суух зөвшөөрөл 329,000 хүн**  
 (Мэргэжлийн болон технологийн салбар)  
 • Зарим ОСЗ нь хилээр нэвтрэхэд “Япон улсын аж үйлдвэр болон иргэдийн аж амьдралд нөлөөлөх нөхцөл байдал” гэх шалгууртай.

**③ Тусгай үйл ажиллагаа 41,000 хүн**  
 (ЕРА-д тогтоосон гадаадын сувилагч, асрамжийн ажилтны дадлагажигч, Working Holiday, гадаадын барилгын ажилчин, гадаадын усан хөлөг онгоцны барилгын ажилчин гэх мэт)  
 • “Тусгай үйл ажиллагаа” ОСЗ-өөр Япон улсад оршин суух гадаад ир-гэд хөдөлмөр эрхлэх боломжтой эсэх нь хүн бүрийн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны агуулгын дагуу шийдэгдэнэ.

**④ Ур чадварын дадлага 384,000 хүн**  
 Ур чадварыг сургаснаар хөгжин буй орнуудад тусламж үзүүлэх зорилготой. 2010 оны 7-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн хилийн шалган нэвтрүүлэх ба цагаачлалыг зөвшөөрөн тогтоох тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ур чадварын дадлагажигчид эхний жилээс хөдөлмөрийн гэрээтэй “Ур чадварын дадлага” ОСЗ-ийг олгох болсон юм. (ОСЗ-ийн төрлийг өөрчилсөн гадаадын иргэдэд ч хамааралтай.)

**⑤ Зөвшөөрлийн бус үйл ажиллагаа** (Гадаад оюутны цагийн ажил зэрэг) **373,000 хүн**  
 • Тус ОСЗ-ийн хүрээнд зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны дагуу Долоо хоногт 28 цагаас илүүгүй г.м тодорхой хэмжээний хөдөлмөр эрхлэх боломжтой.



# Гадаадын ажилтан хүлээн авах тухай

## Өнөөгийн үндсэн бодлого

Мэргэжлийн  
буюу техникийн  
гадаад ажилтан



### Идэвхитэй хүлээн авах

- Япон улсын эдийн засгийн хөгжил, олон улсад улмаар нээлттэй байх үүднээс, мэргэжлийн буюу, технологийн салбарын гадаад ажиллах хүчнийг хүлээн авахыг илүү идэвхитэй эрчимжүүлнэ. (Ажилд авах арга хэмжээний 9 дэх үндсэн төлөвлөгөө (Засгийн газрын шийдвэр))
- Япон улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах мэргэжлийн буюу технологийн салбарт ажиллах гадаад хүний тухайд идэвхитэй хүлээн авах шаард-лагатай бөгөөд, цаашилбал ОСЗ-ийн шийдвэртэй холбоотой хэрэгжилтийг ойлгомжтой болгож, бүртгэлийн ачааллыг хөнгөвчилснөөр илүү урагштай хүлээн авах боломжтой болно. (Хилээр шалган нэвтрүүлэх тухай үндсэн төлөвлөгөө (Хууль зүйн яам))

Бусад гадаад  
ажилтан



### Хэлэлцэх шаардлагатай

- Япон улсын эдийн засгийн нийгэм болон иргэдийн аж амьдралд ихээр нөлөөлөх учир иргэдийн зөвшилцлийн дагуу нарийн хянамгай хандана. (Ажилд авах арга хэмжээний 9 дэх үндсэн төлөвлөгөө (Засгийн газрын шийдвэр))
- Цаашид гадаад иргэдийг хүлээн авах талаар бусад улс орнуудын тогтолцоо болон нөхцөл байдлыг судалж, иргэдийн дуу хоолойг сайтар сонсох ба ажиллах хүчний хомсдлыг нөхөх зорилгоор бий болсон “Тусгай ур чадвартай ажилтан” ОСЗ-ийн хэрэгжилтийн байдал гэх мэтийг үндэслэн засгийн газар нийтээр өргөн хэлэлцүүлгийг хийх шаардлагатай. (Хилээр шалган нэвтрүүлэх тухай үндсэн Төлөвлөгөө (Хууль зүйн яам))



- **Тусгай ур чадвартай ажилтан 1-р зэрэг:** **Тогтсон аж үйлдвэрийн салбарт тодорхой түвшний мэдлэг эсвэл туршлага бүхий ур чадвар** шаардах ажил үүргийг гүйцэтгэх гадаад иргэдэд зориулсан оршин суух зөвшөөрөл
- **Тусгай ур чадвартай ажилтан 2-р зэрэг:** **Тогтсон аж үйлдвэрийн салбарт мэргэжлийн өндөр түвшний ур чадвар** шаардах ажил үүргийг гүйцэтгэх гадаад иргэдэд зориулсан оршин суух зөвшөөрөл

**Тогтсон аж үйлдвэрийн салбар:** Асаргаа, сувилгаа, барилга байгууламжийн цэвэрлэгээ, эд анги, хэв үйлдвэрлэл, аж үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, цахилгаан, цахим мэдээллийн холбогдох үйлдвэрлэл, Барилга, хөлөг онгоц, усан онгоцны үйлдвэрлэл, автомашины засвар үйлчилгээ, агаарын тээвэр, зочид буудал, хөдөө аж ахуй, загас агнуурын аж ахуй, ундаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийтийн хоолны салбар (Ур чадвартай ажилтан 2-р зэрэгт, доогуур зураастай зөвхөн 2 салбарт хүлээн авах боломжтой)


### Тусгай ур чадвартай ажилтан 1-р зэргийн тухай анхаарах зүйлс

- Оршин суух хугацаа: 1 жил, 6 сар эсвэл 4 сар тутамд шинэчлэн **нийт 5 жил хүртэл**
- Ур чадварын түвшин: Шалгалтаар батлан тогтооно (Ур чадварын дадлага 2-р зэргийг амжилттай дүүргэсэн тохиолдолд шалгалтаас чөлөөлөгдөнө)
- Япон хэлний мэдлэгийн түвшин: Амьдрах болон ажлын байранд шаардагдах япон хэлний мэдлэгийн түвшинг шалгалтаар тогтооно (Ур чадварын дадлага 2-р зэргийг амжилттай дүүргэсэн тохиолдолд шалгалтаас чөлөөлөгдөнө)
- Гэр бүлийн гишүүн дагалдан ирэх: Хүлээн зөвшөөрөхгүй
- Хүлээн авагч байгууллага болон бүртгэлтэй дэмжих байгууллагын **тусламж үзүүлнэ**

### Тусгай ур чадвартай ажилтан 1-р зэргийн тухай анхаарах зүйлс

- Оршин суух хугацаа: 3 жил, 1 жил эсвэл 6 сар тутамд шинэчилнэ
- Ур чадварын түвшин: Шалгалтаар батлан тогтооно
- Япон хэлний мэдлэгийн түвшин: Шалгалтаар батлан тогтоох шаардлагагүй
- Гэр бүлийн гишүүн дагалдан ирэх: **Нөхцлийг хангасан тохиолдолд боломжтой. (Эхнэр нөхөр болон хүүхэд)**
- Хүлээн авагч байгууллага болон бүртгэлтэй дэмжих байгууллагын тусламж үл хамаарна

### [Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй ОСЗ-ийн ур чадварын түвшин]





# Салбар бүрийн бодлогууд (14 салбар)

	Салбар	Хөдөлмөрийн хүчний хомсдлын байдал  Хүлэн авах хүний тоо (5 жилийн дээд хэмжээ) (Жич)	Хүний нөөцийн түвшин		Бусад чухал зүйлс		
			Ур чадварын шалгалт	Япон хэлний шалгалт	Гүйцэтгэх ажил	Ажил эрхлэлтийн төрөл	Хүлээн авагч байгууллагад онцлон тавигдах шаардлагууд
Эрүүл мэнд, хөдөлмөрийн яам	Асаргаа, сувилгаа	60,000	Асаргаа, сувилгааны ур чадварын үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)-ын аль нэгнээс гадна Асаргаа, сувилгааны Япон хэлний үнэлгээний шалгалт	<ul style="list-style-type: none"> <li>● Асаргаа, сувилгаа (Үйлчлүүлэгчийн бие махбодь болон сэтгэл зүйн онцлогт тохируулан усанд орох, хооллох, бие засахад нь туслах) -наас гадна туслах ажил (арга хэмжээ зохион байгуулах, дасгал хийхэд туслах гэх мэт) (Жич) Гэрийн туслах үйлчилгээ багтахгүй</li> </ul> <p style="text-align: right;">[1 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМХЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>• ЭМХЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>• Ажлын байр бүрийн хүлээн авах хүний тоогоо тогтоох</li> </ul>
	Барилга байгууламжийн цэвэрлэгээ	37,000	Барилга байгууламжийн цэвэрлэгээний салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Барилга байгууламжийн дотоод цэвэрлэгээ</li> </ul> <p style="text-align: right;">[1 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>• ЭМХЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>• ЭМХЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>• "Барилга байгууламжийн цэвэрлэгээний аж ахуйн нэгж" эсвэл "Барилга байгууламжийн орчны эрүүл ахуйн цогц менежментийн аж ахуйн нэгж"-ийн бүртгэлтэй байх</li> </ul>
Эдийн засаг, аж үйлдвэрийн яам	Эд анги, хэв үйлдвэрлэл	21,500	Үйлдвэрлэлийн салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Цутгамал</li> <li>● Төмөр давталт</li> <li>● Төмөр давталт</li> <li>● Цутгалт</li> <li>● Будалт</li> <li>● Тоног төхөөрөмжийн боловсруулалт</li> <li>● Гагнуур</li> <li>● Металл хэв боловсруулалт</li> </ul> <p style="text-align: right;">[13 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>• ЭЗАҮЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>• ЭЗАҮЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> </ul>
	Аж үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	5,250	Үйлдвэрлэлийн салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Цутгамал</li> <li>● Цахим тоног төхөөрөмжийн угсралт</li> <li>● Төмөр давталт</li> <li>● Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт</li> <li>● Цутгалт</li> <li>● Хэвлэлийн цахилгаан утасны хавтас самбар үйлдвэрлэл</li> <li>● Тоног төхөөрөмжийн боловсруулалт</li> <li>● Тоног төхөөрөмжийн үзлэг</li> <li>● Будалт</li> <li>● Металл боловсруулалт</li> <li>● Төмөрлөг боловсруулалт</li> <li>● Гагнуур</li> </ul> <p style="text-align: right;">[18 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>• ЭЗАҮЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>• ЭЗАҮЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> </ul>
	Цахилгаан, цахим мэдээллийн холбогдох үйлдвэрлэл	4,700	Үйлдвэрлэлийн салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Тоног төхөөрөмжийн боловсруулалт</li> <li>● Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ</li> <li>● Металл хэв боловсруулалт</li> <li>● Цахим тоног төхөөрөмжийн угсралт</li> <li>● Үйлдвэрийн зориулалттай төмөр ялтас</li> <li>● Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт</li> <li>● Аж үйлдвэрийн сав баглаа боолт</li> <li>● Өнгөлгөө</li> <li>● Хэвлэлийн цахилгаан утасны хавтас самбар үйлдвэрлэл</li> <li>● Гүйцэтгэл</li> </ul> <p style="text-align: right;">[13 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>• ЭЗАҮЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>• ЭЗАҮЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> </ul>

## Салбар бүрийн бодлогууд (14 салбар)

Газар нутаг, замын хөдөлгөөний яам	Барилга	40,000	Барилгын салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Барилга угсралт</li> <li>● Дотоод засал,чимэглэл</li> <li>● Шавар</li> <li>● Бетон цутгалт</li> <li>● Туннель сунгах ажил</li> <li>● Барилгын тоног төхөөрөмжийн угсралт</li> <li>● Арматур угсралт</li> <li>● Өндөр барилгын ажилчин</li> <li>● Барилгын мужаан</li> <li>● Сантехникч</li> <li>● Архитектурын хуудас металл</li> <li>● Халуун, хүйтэн барих</li> <li>● Хөөсөн халуун тусгаарлагч</li> <li>● Далай, наран шарлагийн газрын барилгын гүйцэтгэл</li> </ul> <p style="text-align: right;">[18 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>· Гадаад ажилтныг хүлээн авахтай холбоотой барилгын ААН-ийн холбоо байгууллагын гишүүн байх</li> <li>· ГДБТАЖЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· Барилгын тухай хуулийн зөвшөөрөлтэй байх</li> <li>· Япон ажилтантай ижил болон түүнээс дээд хэмжээний цалин хөлсийг тогтмол олгох ба ур чадварын түвшний дагуу нэмэгдэх тухай гэрээгээр заасан байх</li> <li>· Хөдөлмөрийн гэрээний холбогдох чухал зүйлсийг тухайн гадаад ажилтны эх хэлээр нь тэмдэглэсэн бичиг баримттайгаар тайлбарлах</li> <li>· Хүлээн авах барилгын байгууллага бүрт хүлээн авах хүний тооны дээд хэмжээг тогтоох</li> <li>· Цалин хөлсний тухай тэмдэглэсэн "Барилгын тусгай ур чадвартай ажилтныг хүлээн авах төлөвлөгөө" нь ГДБТАЖЯ-ны зөвшөөрөлтэй байх</li> <li>· Зөвшөөрөлтэй "Барилгын тусгай ур чадвартай ажилтныг хүлээн авах төлөвлөгөө"-г амжилттай хэрэгжүүлж байгаа эсэхийг ГДБТАЖЯ-наас шалгуурах</li> <li>· ТУЧА-г "Барилгын ур чадвар хөгжүүлэх систем"-д бүртгүүлэх гэх мэт</li> </ul>
	Хөлөг онгоц, усан онгоцны үйлдвэрлэл	13,000	Хөлөг онгоц, усан онгоцны үйлдвэрлэлийн салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Гагнуур</li> <li>● Будалт</li> <li>● Төмөрлөг боловсруулалт</li> <li>● Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт</li> </ul> <p style="text-align: right;">[6 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>· ГДБТАЖЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ГДБТАЖЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· Бүртгэлтэй дэмжих байгууллагад дэмжлэгийн төлөвлөгөөг даалгах тохиолдолд дээрх шаалдлагыг хангасан байгуулгад даалгах</li> </ul>
	Автомашинны засвар үйлчилгээ	7,000	Автомашинны засвар үйлчилгээний салбарын тусгай ур чадварын үнэлгээний шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Автомашинны өдөр тутмын үзлэг оношлогоо,төлөвлөгөөт үзлэг оношлогоо, задаргааны үзлэг шалгалт</li> </ul> <p style="text-align: right;">[1 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>· ГДБТАЖЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ГДБТАЖЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· Бүртгэлтэй дэмжих байгууллагад дэмжлэгийн төлөвлөгөөг даалгах тохиолдолд дээрх шаалдлагыг хангасан байгуулгад даалгах</li> <li>· Ажиллах газар нь Зам, тээвэр, тээврийн хэрэгслийн тухай хуулийг үндэслэн зөвшөөрөгдсөн байх</li> </ul>
	Агаарын тээвэр	2,200	Тусгай ур чадварын үнэлгээний шалгалт (Агаарын тээврийн салбар: Нисэх буудлын үйлчилгээ, Нисэх онгоцны засвар үйлчилгээ)	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Нисэх буудлын үйлчилгээ (Нисэх зурвас дээрх туслах, гарын тээш, ачаа зөөх ажил гэх мэт)</li> <li>● Нисэх онгоцны засвар үйлчилгээ (Нисэх онгоц болон доторх эд зүйлсийн үзэг оношлогоо)</li> </ul> <p style="text-align: right;">[2 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>· ГДБТАЖЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ГДБТАЖЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· Бүртгэлтэй дэмжих байгууллагад дэмжлэгийн төлөвлөгөөг даалгах тохиолдолд дээрх шаалдлагыг хангасан байгуулгад даалгах</li> <li>· Нисэх буудлын удирдлагын дүрмийг үндэслэн буудал доторх бизнес эрхлэх зөвшөөрөлтэй ААН эсвэл ажиллах газар нь нислэгийн тухай хуулийг үндэслэн нисэх онгоцны засвар үйлчилгээний холбогдох зөвшөөрөлтэй байх</li> </ul>
	Зочид буудал	22,000	Зочид буудлын ажлын ур чадвар тогтоох шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Ресепшин, төлөвлөлт, зар сурталчилгаа, үйлчлүүлэгчид харилцах үйлчилгээ, рестораны үйлчилгээ зэрэг зочид буудлын үйлчилгээг үзүүлэх ажил</li> </ul> <p style="text-align: right;">[1 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>· ГДБТАЖЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ГДБТАЖЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· Бүртгэлтэй дэмжих байгууллагад дэмжлэгийн төлөвлөгөөг даалгах тохиолдолд дээрх шаалдлагыг хангасан байгуулгад даалгах</li> <li>· "Зочид буудлын бизнес"-ийн зөвшөөрөлтэй байх</li> <li>· Зүй бус үйлчилгээний холбоотой байгууллагад тохирохгүй байх</li> <li>· Зүй бус үйлчилгээний холбоотой ажлаар ажиллуулахгүй байх</li> </ul>

## Салбар бүрийн бодлогууд (14 салбар)

Хөдөө аж ахуй, ой мод, усны яам	Хөдөө аж ахуй	36,500	Хөдөө аж ахуйн ур чадвар тогтоох шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Газар тариалан (Тариалангийн менежмент, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг цуглуулах / ачих / ангилах гэх мэт)</li> <li>● Мал аж ахуй (мал тэжээх, бүтээгдэхүүнийг ачих / ангилах гэх мэт)</li> </ul> <p style="text-align: right;">[2 шалгалт]</p>	Шууд Хакэн	<ul style="list-style-type: none"> <li>· ХААОМУЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ХААОМУЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· Бүртгэлтэй дэмжих байгууллагад дэмжлэгийн төлөвлөгөөг даалгах тохиолдолд дээрх шаардлагыг хангасан байгуулгад даалгах</li> <li>· Хөдөмөр эрхлэгчийг тодорхой хугацаанд ажилд авсан туршлагатай хөдөө аж ахуйн нэгж байх</li> </ul>
	Загас агнуурын аж ахуй	9,000	Загас агнуурын аж ахуйн ур чадвар тогтоох шалгалт (Загас агнуурын аж ахуй эсвэл үржүүлгийн аж ахуй) (Албан бус)	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Загас агнуурын аж ахуй (Загас барих хэрэгсэл үйлдвэрлэх, засварлах, далайн амьтан, ургамлыг олох, загас агнуурын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ажиллуулах, далайн амьтан, ургамлыг цуглуулах, барих, боловсруулах, хадгалах, эрүүл ахуйн шаардлага ба аюулгүй байдлыг хангах гэх мэт)</li> <li>● Үржүүлгийн аж ахуй (Далайн амьтан тэжээх хэрэгслийг үйлдвэрлэх / засварлах, менежмент хийх, Усны амьтан, ургамлыг тэжээх / боловсруулах, эрүүл ахуйн шаардлага ба аюулгүй байдлыг хангах гэх мэт)</li> </ul> <p style="text-align: right;">[2 шалгалт]</p>	Шууд Хакэн	<ul style="list-style-type: none"> <li>· ХААОМУЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ХААОМУЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· ХААОМУЯ-ны зохион байгуулах хуралдаанд шийдсэн шийдвэрийн дагуу ажиллах</li> <li>· Бүртгэлтэй дэмжих байгууллагад дэмжлэгийн төлөвлөгөөг даалгах тохиолдолд зөвхөн салбарын тусгай шаардлагыг хангасан байгууллагыг сонгон томилох</li> </ul>
	Ундаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	34,000	Ундаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн ур чадвар тогтоох шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Ундаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл (Согтууруулах ундаанаас бусад хүнс ундааны үйлдвэрлэл, боловсруулалт, эрүүл ахуйн шаардлага ба аюулгүй байдлыг хангах гэх мэт)</li> </ul> <p style="text-align: right;">[1 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>· ХААОМУЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ХААОМУЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> </ul>
	Нийтийн хоолны салбар	53,000	Нийтийн хоолны салбарын тусгай ур чадвар 1-р зэргийн ур чадвар тогтоох шалгалт	"Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (Япон сан) эсвэл Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)	<ul style="list-style-type: none"> <li>● Нийтийн хоолны салбар (Тогооч, үйлчлэгч, менежер)</li> </ul> <p style="text-align: right;">[1 шалгалт]</p>	Шууд	<ul style="list-style-type: none"> <li>· ХААОМУЯ-ны зохион байгуулах хуралдаанд оролцож хамтран ажиллах</li> <li>· ХААОМУЯ-ны судалгаа болон удирдажийг хүлээн авч хамтран ажиллах</li> <li>· Зүй бус үйлчилгээний холбоотой байгууллагад ажиллуулахгүй байх</li> <li>· Зүй бус үйлчилгээний холбоотой ажлаар ажиллуулахгүй байх</li> </ul>

(Жич) 14 салбарын нийт хүлээн авах тоо (5 жилийн дээд хэмжээ): 345,150

# Ур чадварын дадлага болон тусгай ур чадварын тогтолцооны Харьцуулалт (Ерөнхий агуулга)



出入国在留管理庁  
Хилийн шалган нэвтрүүлэх,  
оршин суух хяналтын газар

	Ур чадварын дадлага (Тухайн байгууллага хариуцана)	Тусгай ур чадвар ( 1 -р зэрэг)
<b>Холбогдох хууль</b>	Гадаадын ур чадварын дадлагын зүй зохистой хэрэгжилт, ур чадварын дадлагажигчийг хамгаалах тухай хууль ¥Хилээр шалган нэвтрүүлэх ба дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх тухай хууль	Хилээр шалган нэвтрүүлэх ба Дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх тухай хууль
<b>Оршин суух зөвшөөрөл</b>	ОСЗ "Ур чадварын дадлага"	ОСЗ "Тусгай ур чадвартай ажилтан"
<b>Оршин суух хугацаа</b>	Ур чадварын дадлага 1-р зэрэг: 1 жил хүртэл, Ур чадварын дадлага 2-р зэрэг: 2 жил хүртэл, Ур чадварын дадлага 3-р зэрэг: 2 жил хүртэл (Нийт 5 жил хүртэл)	Нийт 5 жил
<b>Гадаад иргэний ур чадварын түвшин</b>	Шаардахгүй	Тодорхой түвшний мэдлэг эсвэл туршлага шаардагдана
<b>Урьдчилан өгөх шалгалт</b>	Шаардахгүй (Зөвхөн асрамжийн ажилтан хилээр нэвтрэхэд N4 түвшний Япон хэлний шалгалтанд тэнцэх шаардлагатай)	Ур чадварын болон Япон хэлний мэдлэгийн түвшинг шалгалтаар тогтооно (Ур чадварын дадлага 2-р зэргийг амжилттай төгссөн тохиолдолд шалгалтаас чөлөөлөгдөнө)
<b>Зуучлах байгууллага</b>	Гадаад орны засгийн газрын баталгаа эсвэл зөвшөөрөлтэй байгууллага	---
<b>Хариуцах байгууллага</b>	Байна(Ашигийн бус аж ахуйн нэгж салбарын яамны сайдын зөвшөөрлөөр дадлагажигчийн хяналт болон холбогдох үйл ажиллагааг хариуцана. )	---
<b>Дэмжигч байгууллага</b>	---	Байна(Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт бүртгэлтэй хувь хүн, эсвэл байгууллага хүлээн авагч байгууллагын хүсэлтээр тусгай ур чадвартай гадаадын ажилтны оршин суух байрыг олох болон бусад дэмжлэгийг үзүүлнэ.)
<b>Гадаадын иргэд ба хүлээн авагч байгууллагын зуучлал</b>	Ерийн хариуцах байгууллага болон зуучлах байгууллагаар дамжуулна	Хүлээн авагч байгууллага нь гадаадын орнуудаас ажилчдыг шууд сонгох, эсвэл дотоод болон гадаадын зуучлалын байгууллагаар дамжуулан ажилчдыг сонгох боломжтой
<b>Хүлээн авагч байгууллага тус бүрийн хүний тооны хязгаар</b>	Байнгын ажилтны нийт тооноос хамааран хязгаарлагдана	Хүний тооны хязгааргүй (Асаргаа сувилгаа, барилгын салбараас бусад)
<b>Үйл ажиллагааны агууллага</b>	Ур чадварын дадлагын төлөвлөгөөний дагуу, сургалтад хамрагдах, ур чадварт холбогдох хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа (1-р зэрэг) Ур чадварын дадлагын төлөвлөгөөний дагуу ур чадвар шаардах хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа (2, 3-р зэрэг) (Мэргэжлийн, мэргэжлийн бус технологийн салбар)	Тодорхой түвшний мэдлэг, эсвэл туршлага бүхий ур чадвар шаардах үйл ажиллагаа (Мэргэжлийн, технологийн салбар)
<b>Ажлын байраа солих</b>	Боломжгүй. Харин дадлагажуулагч нь дампуурсан гэх мэтийн зайлшгүй тохиолдолд, эсвэл 2-р зэргээс 3-р зэрэг рүү шилжих үед ажлын байраа солих боломжтой.	Ажлын ангиллынхаа дотор, эсвэл ижил ур чадварын түвшин шаардахыг шалгалтаар тогтоосон ангиллын хооронд ажлын байраа солих боломжтой.

# Тогтолцооны ерөнхий агуулга ② Хүлээн авагч байгууллага болон бүртгэлтэй дэмжих байгууллагын тухай



## Хүлээн авагч байгууллагын тухай

- 1 Хүлээн авагч байгууллагууд гадаад иргэдийг хүлээн авахад тавигдах шаардлагууд**
  - ① Гадаад иргэнтэй байгуулах хөдөлмөрийн гэрээ нь тохиромжтой байх (Жишээ: Цалингийн хэмжээ нь Япон ажилчидтай адил, эсвэл түүнээс дээш байх)
  - ② Байгуулга нь зөв шударга үйл ажиллагаа явуулдаг байх (Жишээ: Сүүлийн 5 жилд хилээр нэвтрэх болон хөдөлмөрийн холбоотой хуулийг зөрчөөгүй байх)
  - ③ Гадаад иргэдийг дэмжих бүтэц зохион байгуулалттай байх (Жишээ: Гадаад иргэдийн ойлгодог хэлээр дэмжлэг үзүүлдэг)
  - ④ Гадаад иргэдийг дэмжихэд зохих төлөвлөгөөтэй байх (Жишээ: Аж амьдралын орчны зөвөлгөө өгөх)
- 2 Хүлээн авагч байгууллагын үүрэг**
  - ① Гадаад иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг зөрчилгүйгээр гүйцэтгэх (Жишээ: Зохих хэмжээний хөлс олгох)
  - ② Гадаад иргэдэд зохих тусламж үзүүлэх  
→ Аж амьдралын тусламжийг бүртгэлтэй дэмжих байгууллагад даалгах боломжтой. Бүгдийг нь даалгасан тохиолдолд 1 ③ үүрэг албаар гүйцтгэгдэнэ.
  - ③ Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар (ХШНОСХГ)-т зохих мэдүүлэг өгөх (Анхааруулга) ①~③ үүргээс татгалзсан тохиолдолд гадаад иргэдийг хүлээн авах эрхийг цуцлаж ГИХЕГ-аас анхааруулга өгөх гэх мэт байна.

## Бүртгэлтэй дэмжих байгууллагын тухай

- 1 Бүртгүүлэхэд тавигдах шаардлагууд**
  - ① Байгуулга нь тохиромжтой үйл ажиллагаа явуулдаг байх (Жишээ: Сүүлийн 5 жилд хилээр нэвтрэх болон хөдөлмөрийн холбоотой хуулийг зөрчөөгүй байх)
  - ② Гадаад иргэдийг дэмжих бүтэц зохион байгуулалттай байх (Жишээ: Гадаад иргэдийн ойлгодог хэлээр дэмжлэг үзүүлдэг)
- 2 Бүртгэлтэй дэмжих байгууллагын үүрэг**
  - ① Гадаад иргэдэд зохих тусламж үзүүлэх
  - ② ХШНОСХГ-т төрөл бүрийн өргөдөл гаргах (Жич) ①② үүргийг гүйцтгэхгүй тохиолдолд бүртгэлээс хасагдах магадлалтай.





### Хилийн чанадаас ирэх гадаад иргэн

Ур чадварын дадлага  
2-р зэргийг амжилттай  
дүүргэсэн иргэн

Ур чадварын болон Япон  
хэлний шалгалтаас  
чөлөөлөгдөнө

Хилийн чанадаас  
шинээр орж ирэхээр  
төлөвлөж буй гадаад  
иргэн

Гадаад улсад  
ур чадварын болон Япон  
хэлний шалгалтад тэнцэх

<Ур чадварын шалгалт>

- Тусгай аж үйлдвэрийн салбарын ажлын ангиллын дагуу шалгалт

<Япон хэлний шалгалт>

- "Япон сан"-гийн Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт

(Япон сан)  
эсвэл

- Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт (N4-өөс дээш)

(Япон сан · Японы Олон улсын боловсролыг дэмжих холбоо)

гэх мэт



### Япон улсад оршин сууж буй гадаад иргэн (Дунд болон урт хугацааны оршин суугч)

Ур чадварын дадлага  
2-р зэргийг амжилттай  
дүүргэсэн гадаад иргэн

Ур чадварын болон  
Япон хэлний шалгалтаас  
чөлөөлөгдөнө

Гадаад оюутан

Гадаад улсад  
ур чадварын болон Япон  
хэлний шалгалтад тэнцэх

Ажлын зарыг хараад шууд холбогдох / Хувийн компаниар зуучлуулах

Ажлын зарыг хараад шууд холбогдох / Хөдөлмөр зуучлалын байгууллага эсвэл хувийн компаниар зуучлуулах

[Хүлээн авагч байгууллагатай хөдөлмөрийн гэрээг байгуулах]  
Хүлээн авагч байгууллагаас урьдчилан зааварчилга өгөх  
Эрүүл мэндийн шинжилгээгээ өгөх

Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах  
мэдүүлэг өгөх

\* Хүлээн авагч байгууллагын ажилтан төлөөлөн мэдүүлнэ

Шалгалт

Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах

Хүлээн авагч байгууллагад ОСЗ-ийн гэрчилгээг илгээх

Виз мэдүүлэх

\* Хүлээн авагч байгууллагаас ирсэн ОСЗГ-г консулын газарт өгөх

Консулын  
газар

Шалгалт

Виз гаргах

Хилээр нэвтрэх

Оршин суух үнэмлэх авах.  
\* Хилээр нэвтрэхний дараа авах боломжтой

Орон нутгийн хилийн  
шалган нэвтрүүлэх  
газар



Оршин суух зөвшөөрлийн ангилалыг  
шинэчлэх мэдүүлэг өгөх

\* Төлөөлөн мэдүүлэх боломжгүй

Шалгалт

Оршин суух зөвшөөрлийн  
ангилалыг шинэчлэгдэх

Оршин суух үнэмлэх авах

[Бүртгүүлэгчид тавигдах шаардлагууд]

- 18 насанд хүрсэн байх
- Ур чадварын шалгалт болон Япон хэлний шалгалтад тэнцсэн байх (Ур чадварын дадлага 2-р зэргийг амжилттай дүүргэсэн гадаад иргэн шалгалтаас чөлөөлөгдөнө)
- Тусгай ур чадвартай ажилтан 1-р зэргийн визээр нийт 5 - аас дээш жил оршин суугаагүй байх
- Барьцааны мөнгө төлөх шаардлагагүй байх, эсвэл торгуулийн мөнгөтэй ямар нэгэн гэрээ байгуулаагүй байх
- Хувь хүнээр ямар нэгэн төлбөр төлөх шаардлагатай тохиолдолд агуулгыг нь сайтар ойлгосон байх гэх мэт

- [Хилээр нэвтрэхний дараа (эсвэл оршин суух зөвшөөрлийн ангилал өөрчлөгдсөний дараа) заасан хугацаанд хэрэгжүүлэх зүйлс]
- Хүлээн авагч байгууллагын зохион байгуулах Япон улсад амьдрах талаарх сургалтад хамрагдах
  - Оршин суух хот, дүүрэгт оршин суух бүртгэл хийлгэх
  - Цалинг авах данс нээгдэх
  - Амьдрах байраа олох гэх мэт

Хүлээн авагч байгууллагад ажиллаж эхэлнэ



## Гол агуулга

- Хүлээн Авагч Байгууллага (ХАБ) 1-р зэрэглэлийн тусгай ур чадвартай гадаад ажилтанд “Тусгай ур чадвар 1-р зэрэг”-ийн үйл ажиллагааг амжилттай, тасралтгүйгээр явуулахад хөдөлмөр эрхлэхэд болон ахуйн амьдралын, нийгэм дэх орчныг хангах дэмжлэг үзүүлэх тухай төлөвлөгөөг (“Дэмжлэгийн төлөвлөгөө” гэнэ) гаргаж түүний дагуу дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

\* Тусгай ур чадварын 2-р зэргийн тухай дэмжлэг үзүүлэх үүрэггүй.

## ■ Дэмжлэгийн төлөвлөгөө гаргах

- ХАБ нь оршин суухтай холбогдох төрөл бүрийн мэдүүлэг (\*) өгөхөд дэмжлэгийн төлөвлөгөөг гаргаж бусад бичиг баримтуудтай хамтад нь өгөх шаардлагатай.

\* Тусгай ур чадвар 1-р зэрийн холбогдох ОСЗ-ийн гэрчилгээ авах мэдүүлэг, ОСЗ-ийн ангилалыг шинэчлэх мэдүүлэг гэх мэт

## ■ Дэмжлэгийн төлөвлөгөөнд тэмдэглэх гол зүйлс

- Хөдөлмөр эрхлэхэд болон аж амьдралын, нийгэм дэх орчныг хангахад хэрэгтэй хэмээн сайдын захирам-жаар тогтоосон 10 зүйл (14-р нүүрт тэмдэглэсэн байх болно)-ийн дэмжлэгийн агуулга, арга, дэмжлэгийг
- хариуцах хүний нэрс болон албан тушаал гэх мэт
- Дэмжлэгийг гэрээгээр бусад этгээдэд даалгах тохиолдолд тухайн хувь хүн болон байгууллагын нэр, хаяг болон бусад мэдээлэл
- Бүртгэлтэй Дэмжих Байгууллага (БДБ) (Зөвхөн бүртгэлтэй дэмжих байгууллагад даалгах тохиолдолд)

## ■ Дэмжлэгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх БДБ-д даалгах тухай

- ХАБ нь дэмжлэгийн төлөвлөгөөг бүрэн болон нэг хэсгийг бусад этгээдэд даалгах боломжтой (Дэмжлэгийг даалгах гэрээ байгуулах шаардлагатай).
- ХАБ дэмжлэгийн төлөвлөгөөг БДБ (15-р нүүрт тэмдэглэсэн байх болно) бүрэн даалгах тохиолдолд гадаад иргэдийг дэмжих бүтэц зохион байгуулалттай хэмээн үзэх болно.
- БДБ нь даалгагдсан үүргээ бусад этгээдэд шилжүүлэх боломжгүй. (Дэмжлэгийн хүрээнд орчуулагч зэргээр туслуулахыг зөвшөөрнө)



# Дэмжлэгийн төлөвлөгөөний ерөнхий агуулга②

## ① Урьдчилсан сургалт

- Хөдөлмөрийн гэрээ байгуулсны дараа ОСЗ-ийн гэрчилгээг авах мэдүүлэг өгөхийн өмнө эсвэл ОСЗ-ийн ангиллыг шинэчлэх мэдүүлэг өгөхийн өмнө хөдөлмөрийн нөхцөл, үйл ажиллагааны агуулга, хилээр нэвтрэхэд хийх ажил, баталгааны мөнгийг төлөх эсэх зэрэг асуудлуудын тухай уулзалт эсвэл дүрстэй яриагаар танилцуулана.



## ② Хилээр нэвтрэх ба гарах үеэр тосож авах, хүргэх

- Хилээр нэвтрэх үеэр нисэх буудлаас тосож оффис эсвэл амьдрах байр руу хүргэнэ
- Эх орон руугаа харих үед нь нисэх буудлын аюулгүй байдлын хяналтын цэг рүү хүргэнэ



## ③ Амьдрах байр болон бусад гэрээ байгуулахад туслах

- Батлан даах үйлчилгээ
- Ажилчдын дотуур байранд амьдруулах гэх мэт
- Банкны дансаа нээх
- Гар утас болон тог, ус, газны гэрээний талаар мэдээлэл өгөх
- Бусад хэрэгтэй зүйлд тусална



## ④ Аж амьдралын талаарх сургалт

- Япон улсад дасан амьдрахын тулд нийгэм дэх дүрэм журам, олон ний-тийн тээвэр ашиглах, байгалийн гамшиг тохиосон үед авах арга хэмжээ зэргийг танилцуулна.



## ⑤ Захиргааны газарт хамт очих

- Амьдарч буй хот, дүүрэг, нийгмийн даатгал, татвар зэрэг албан бичгийг бөглөх, захиргааны газарт өгөхөд тусална.



## ⑥ Япон хэл сурах орчныг бүрдүүлэх

- Япон хэлний сургуулийг танилцуулах, сурах бичгийн тухай мэдээлэл өгөх гэх мэт.



## ⑦ Зөвөлгөө өгөх

- Ажлын байр болон аж амьдрал дээр тулгамдсан асуудлын талаар тухайн гадаад иргэний ойлгодог хэлээр хандан зөвөлгөө өгнө.



## ⑧ Япон хүмүүстэй харилцах орчныг бүрдүүлэх

- Оршин сууж буй газрын иргэдтэй харилцах, баяр наадам болон арга хэмжээнд оролцоход тусална.



## ⑨ Ажлын байраа солиход туслах (Хүний нөөцийн цомхотгол гэх мэтийн тохиолдолд)

- Хүлээн авагчийн асуудлаас болж хөдөлмөрийн гэрээг цуцлуулах зайлшгүй тохиолдолд дараагийн ажлын байрыг хайн олоход туслах, батламжийн бичгийг бөглөх, ажил олдох хүртэлх хугацааны төлбөртэй чөлөө олгох, захиргааны газарт бүртгүүлэх шаардлагатай зүйлсийн мэдээлэл өгөх гэх мэт.



## ⑩ Тогтмол уулзалт хийн асуудлыг мэдээлэх

- Дэмжлэгийн хариуцагч этгээд, гадаад иргэн болон түүний даргатай нь 3 сард 1-ээс дээш удаа тогтмол уулзаж, хөдөлмөрийн тухай хуулийн зөрчил илэрсэн тохиолдолд захиргааны газарт дуудлага өгнө.






# Бүртгэлтэй дэмжих байгууллага гэж юу вэ?



БДБ-аар ажиллах хүсэлтэй хувь хүн эсвэл Аж Ахуйн Нэгж (ААН)



## Бүртгэлтэй дэмжих байгууллага гэж юу вэ?

- БДБ нь ХАБ-тай байгуулсан, дэмжлэгийг даатгах гэрээний дагуу дэмжлэгийн төлөвлөгөөнд үндэслэсэн бүх дэмжлэгийг үзүүлнэ.
- БДБ нь үйл ажиллагаа явуулахын тулд ХШНОСХГ-ын даргын бүртгэл шаардлагатай.
- Бүртгүүлсэн байгууллага БДБ-ын бүртгэлийн дэвтэрт бүртгэн ХШНОСХГ-ын цахим хуудаст тэмдэглэнэ.
- Бүртгэлийн хугацаа нь 5 жил бөгөөд сунгагдах боломжтой.
- Бүртгүүлэхэд дараах төлбөр төлөх шаардлагатай. (Шинээр бүртгүүлэхэд: 28,400иен, Бүртгэлийг шинэчлэх 11,100 иен)
- БДБ нь ХШНОСХГ-ын даргад тогтмол эсвэл байнгын өргөдөл гаргах шаардлагатай.

## Гол агуулга

- ХАБ болон БДБ нь ХШНОСХГ-ын даргад өргөдлийг хэзээд эсвэл тогтмол өгөх шаардлагатай
- ХАБ энэхүү хариуцлагыг биелүүлээгүй эсвэл худал мэдээлэлтэй өргөдөл өгсөн тохиолдолд хариуцлага тооцоно.

### ■ ХАБ-ын өргөдөл \* Зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага тооцоно.

#### 【Хэзээд өгөх өргөдөл】

- Тусгай ур чадварын хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт орсон, хугацаа нь дууссан, шинээр байгуулах тухай өргөдөл
- Дэмжлэгийн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тухай өргөдөл
- БДБ -тай дэмжлэгийг даатгах гэрээ байгуулсан, өөрчлөлт орсон, хугацаа нь дууссан тухай өргөдөл
- Тусгай ур чадвартай ажилтныг хүлээн авахад бэрхшээл тулгамдсан талаарх өргөдөл
- Хилээр нэвтрэх, гарах болон хөдөлмөрийн холбоотой хуулийн зөрчлийн тухай мэдээлэл авсан тохиолдлын өргөдөл

#### 【Тогтмол өгөх өргөдөл】

- Тусгай ур чадвартай ажилтныг хүлээн авч буй нөхцөл байдлын тухай өргөдөл (Жишээ: Тусгай Ур Чадвартай Ажилтны (ТУЧА) нийт тоо, хувийн мэдээлэл, үйл ажиллагаа явуулсан хугацаа, байршил, ажлын агуулга гэх мэт)
- Дэмжлэгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлын тухай өргөдөл (Жишээ: Асуудлын агуулга болон ямар зөвөлгөө өгсөн, дүгнэлт гаргасан гэх мэт) \* Дэмжлэгийн төлөвлөгөөг БДБ-д бүрэн даалгасан тохиолдолд хамаарахгүй.
- Тусгай ур чадвартай ажилтны үйл ажиллагааны байдлын тухай өргөдөл  
(Жишээ: Цалин төлсөн байдал, ажлаасаа гарсан хүний тоо, сураггүй болсон хүний тоо, хүлээн авахад зарцуулсан зардал гэх мэт)

### ■ БДБ-ын өргөдөл

\* Зөрчил илэрсэн тохиолдолд анхааруулга өгөх эсвэл бүртгэлийг цуцална

#### 【Хэзээд өгөх өргөдөл】

- Бүртгэлийн хүсэлт гаргахад өөрчлөлт орсон тухай өргөдөл
- Дэмжлэгийг түр зогсоох болон хүчингүй болгох өргөдөл

#### 【Тогтмол өгөх өргөдөл】

- Дэмжлэгийн хэрэгжилтийн байдлын тухай өргөдөл ]  
(Жишээ: ТУЧА-ны нэр, ХАБ-ын нэр, ТУЧА-наас ирсэн асуулт болон ямар зөвөлгөө өгсөн гэх мэт)

#### 【Тогтмол өгөх өргөдөл】 \* ХАБ, БДБ


- Улирал бүрт дараагийн улиралын эхний өдрөөс 14 хоногийн дотор өгнө
- ① 1-р улирал: 1-р сарын 1-нээс 3-р сарын 31 хүртэл
- ② 2-р улирал: 4-р сарын 1-нээс 6-р сарын 30 хүртэл
- ③ 3-р улирал: 7-р сарын 1-нээс 9-р сарын 30 хүртэл
- ④ 4-р улирал: 10-р сарын 1-нээс 12-р сарын 31 хүртэл



## Гол агуулга

- Тогтолцоог амжилттай ажиллуулахын тулд холбогдох яаманд тусгай аж үйлдвэрийн салбар бүрийн зөвлөл байгуулна.
- Зөвлөлийн үүрэг нь гишүүдийн хооронд хамтран ажиллаж орон нутаг бүрийн Аж Ахуйн Нэгж/ААН/-д хэрэгтэй ТУЧА-ыг хүлээн авахад тогтолцоо болон мэдээллийг түгээх, хууль захирамжийг мөрдүүлэх, орон нутгийн хөдөлмөрийн хүчний хомсдолын байдлыг танин мэдэж, тохиромжтой арга хэмжээг нь авна.

## Зураглал



## Үйл ажиллагааны агуулга

- ТУЧА-ыг хүлээн авахад холбогдох тогтолцооны ерөнхий агуулга болон амжилт гаргасан жишээг мэдээлэх
- ТУЧ-ын харья байгууллагад хууль захирамжийг баримтуулах
- Хөдөлмөрийн бүтцийн болон санхүүгийн байдлын өөрчлөлтийн тухай мэдээллийг цуглуулах, шинжилгээ хийх
- Орон нутгуудын хөдөлмөрийн хүчний хомсдолын байдлыг танин мэдэх, шинжилгээ хийх
- Хөдөлмөрийн хүчний хомсдол, хүлээн авч буй нөхцөл байдлын дагуу хүн амын хэт төвлөрлөөс зайлсхийх арга хэмжээг хэлэлцэх (Аль нэг газар нутагт хэт төвлөрсөн тохиолдолд гишүүдэд гомдол гаргах гэх мэт)
- Хүлээн авалтын амжилттай, тохиромжтой хэрэгжилтийн төлөөх бусад мэдээллийг солилцон хэлэлцэх гэх мэт



## Засгийн газрын үндсэн бодлого (2018 оны 12-р сарын 25-нд ЗГ-ын хуралдаанаар батлагдсан)

Баталгааны мөнгийг авах зэргийн харгис хэрцгийн зуучлагч/брокер/-ийн үйл ажиллагааг урьдчилан сэргийлэхийн төлөө хоёр талын гэрээ гэх мэт хоёр улсын засгийн газар хоорондын баримт бичиг үүсгэн зохих арга хэмжээг авна.


## Цогц арга хэмжээ (2018 оны 12-р сарын 25-нд ЗГ-ын хуралдаанаар батлагдсан)

- Гадаад ажилтныг зөв зохистой хүлээн авахыг эрчимжүүлэхийн төлөөх арга хэмжээ: харгис хэрцгийн зуучлагчтай тэмцэх  
Гадаад ажилтнаар Япон улс руу явуулах бодлоготой болон Япон хэлний шалгалтыг өгч болох 9 орон (“Давуу эрхтэй 9 орон” гэнэ)-той хамтран харгис хэрцгийн зуучлагчтай тэмцэх зорилгоор мэдээлэл солилцохыг заасан хоёр талын гэрээний төлөөх засгийн газар хоорондын баримт бичиг үүсгэхийг зорин, дээрх 9 орноос бусад ажилчин явуулах бодлоготой улс оронтой ижил агуулгатай баримт бичиг үүсгэхээр хэрэлцээр хийнэ.

## Хоёр талын гэрээний гол агуулга

- Мэдээлэл солилцох  
ТУЧА-ныг тогтвортой явуулах, хүлээн авахад хэрэгтэй эсвэл ашигтай мэдээллийг шуурхай солилцоно. Энэхүү мэдээлэлд ТУЧА-ны хамаарах хүний нөөцийн талаарх хоёр улсын байгууллагуудын дараах үйл явдлын тухай мэдээлэл багтана
  - Баталгааны мөнгийг авах, торгуулийн мөнгө заасан, хүний эрхийн зөрчил, хуурамч бичиг баримт бүрдүүлэх, зардлыг шударга бусаар цуглуулах гэх мэт
- Асуудлыг шийдэх хэлэлцээр  
Тогтмол эсвэл байнга хэлэлцээр хийж, тус тогтолцооныг амжилттай хэрэгжүүлэхэд сайжруулах шаардлагатай асуудлыг шийдэхийн төлөө тууштай ажиллана.

## Хоёр талын гэрээний зураглал



## Гарын үсэг зурсан орнууд (11 улс)

(2019 оны 12-р сарын сүүлчийн байдлаар, МОС-ийг байгуулах санаа илэрхийлсэн орнуудыг тод үсгээр


тэмдэглэсэн байна)

**Филиппин (3.19), Камбож (3.25), Балба (3.25), Мьянмар (3.28), Монгол (4.17), Шри Ланка (6.19), Индонез (6.25), Вьетнам (7.1 Баримт бичиг солилцов), Бангладеш (8.27), Узбекистан (12.17), Пакистан (12.23)**




## ТУЧА-ны зөвшөөрөл хүлээсэн байдлын тухай (2019 оны 12-р сарын сүүлчийн байдал : шуурхай мэдээ)

① ОСЗ-ийн гэрчилгээ гарсан	1,139
② ОСЗ-ийн өөрчлөлт зөвшөөрсөн	1,062
③ БДБ-д бүртгэсэн	3,451
④ Тусгай арга хэмжээгээр	857
“Тусгай үйл ажиллагаа” зөвшөөрсөн	(Хүлээн аваагүй тохиолдлыг агуулна)




## Зөвшөөрлийн тоо



## Оршин суугаа ТУЧА-ын тоо (2019 он 11-р сарын сүүлчийн байдал : шуурхай мэдээ)

ТУЧ 1-р зэрэглэлтэй оршин суугчийн тоо 1,019



Салбар	Хүний тоо
Асаргаа, сувилгаа	19
Барилга байгууламжийн цэвэрлэгээ	12
Эд анги, хэв үйлдвэрлэл	143
Аж үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	151
Цахилгаан, цахим мэдээллийн холбогдох үйлдвэрлэл	31
Барилга	59
Хөлөг онгоц, усан онгоцны үйлдвэрлэл	32
Автомашин засвар үйлчилгээ	8
Агаарын тээвэр	0
Зочид буудал	13
Хөдөө аж ахуй	169
Загас агнуурын аж ахуй	8
Ундаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	303
Нийтийн хэрэгсэл салбар	



**УЧ-ын шалгалтын хэрэгжилт (2019 оны 12-р сарын сүүлчийн байдал. Шалгалт авсан байгууллагуудын цахим хуудас дээрх мэдээлэл)**

	Байршил (Он, сар)	Шалгуулагчийн тоо	Тэнцэгчийн тоо	Цаашдын төлөвлөгөө (Жич 1)
Асаргаа сувилгаа	(Филиппин) 2019.4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 (Камбож) 2019.9, 10, 11, 12 (Индонез) 2019.10, 11, 12 (Балба) 2019.10, 11, 12 (Монгол) 2019.11, 12 (Япон) 2019.10, 11, 12	(Ур чадварын шалгалт) 2,634 (Жич 2) (Япон хэлний шалгалт) 2,612 (Жич 2)	(Ур чадварын шалгалт) 1,254 (Жич 2) (Япон хэлний шалгалт) 1,285 (Жич 2)	(Филиппин) 2020.1 (Камбож) 2020.1 (Индонез) 2020.1 (Балба) 2020.1
Барилга байгууламжийн цэвэрлэгээ	(Мьянмар) 2019.12 (Япон) 2019.11, 12	472	317	—
Эд анги, хэв үйлдвэрлэл (Жич 3) Аж үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл (Жич 3) Цахилгаан, цахим мэдээллийн холбогдох үйлдвэрлэл (Жич 3)	—	—	—	(Индонез) 2020.1
Хөлөг онгоц, усан онгоцны үйлдвэрлэл (Жич 3)	(Филиппин) 2019.11	(Жич 2)	(Жич 2)	—
Автомашин засвар үйлчилгээ	(Филиппин) 2019.12	12	12	(Филиппин) 2020.1, 2, 3
Агаарын тээвэр (Жич 3)	(Филиппин) 2019.11 (Монгол) 2019.10 (Япон) 2019.11	227	128	(Япон) 2020.2
Зочид буудал	(Мьянмар) 2019.10 (Япон) 2019.4, 10	1,280	728	(Япон) 2020.1
Хөдөө аж ахуй (Жич 3)	(Филиппин) 2019.10, 11, 12	9 (Жич 2)	9 (Жич 2)	(Филиппин) 2020.1, 2, 3 (Камбож) 2020.1, 2, 3 (Индонез) 2020.1, 2, 3
Загас агнуурын аж ахуй (Жич 3)	—	—	—	(Индонез) 2020.1
Ундаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	(Филиппин) 2019. 11, 12 (Япон) 2019.10	626 (Жич 2)	433 (Жич 2)	(Филиппин) 2020.1, 2, 3 (Индонез) 2020.1, 2, 3 (Япон) 2020.2
Нийтийн хоолны салбар	(Филиппин) 2019. 11, 12 (Япон) 2019.4, 6, 9, 11	4,717 (Жич 2)	2,966 (Жич 2)	(Филиппин) 2020.1, 2, 3 (Камбож) 2020.1, 2, 3 (Япон) 2020.2
“Япон сан” Япон хэлний суурь мэдлэгийн шалгалт	(Филиппин) 2019.4, 5, 6, 8, 9, 10, 11 (Камбож) 2019.10 (Индонез) 2019.10, 11 (Балба) 2019.10, 11 (Монгол) 2019.11	2,279	779	(Филиппин) 2020.1 (Камбож) 2020.1 (Индонез) 2020.1 (Балба) 2020.1

(Жич1) 1-р сараас хойших төлөвлөгөө нь өөрчилж болно.

(Жич2) 10-р сараас хойших Асаргаа, сувилгаа (Ур чадварын болон Япон хэлний шалгалт), Барилга байгууламжийн цэвэрлэгээ, Хөлөг онгоц, усан онгоцны үйлдвэрлэл, Агаарын тээвэр (Нисэх буудлын үйлчилгээ), Хөдөө аж ахуй, Ундаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, Нийтийн хоолны салбар болон “Япон сан”

Япон хэлний суурь мэдлэгийн шалгалтын шалгуулагч болон тэнцэгчдийн тоо нь нийтгэгдээгүй байгаа тул нийт тоонд оруулагдаагүй байна.

(Жич 3) Ажлын ангилал бүрт шалгалтын зохион байгуулалтын байдал өөр байх болно.

## **Үндсэн бодлого, эрх бүхий яамны захирамжийн тухай**

---

# ТУЧ-ын ОСЗ-ийн холбоотой тогтолцооны хэрэгжилтийн талаарх үндсэн бодлогын ерөнхий агуулга

